

ЭРДМИЙН БАГА ЧУУЛГАН -2017 ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

АШУҮИС-ийн харьяа Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн багш нарын “Эрдмийн бага чуулган 2017” эрдэм шинжилгээний хурал 2017 оны 3-р сарын 24-ний өдөр, амжилттай зохион байгуулагдлаа.

Энэхүү хурал нь Сургалт, Эрдэм шинжилгээний хурал гэсэн үндсэн 2 хэсгээр явагдсанаараа онцлог болсон. АШУҮИС-ийн НЭМС-ийн багш АУ-ны доктор Д.Гантуяа “Судалгааны арга зүй”, “Эрдэм шинжилгээний өгүүллийг хэрхэн сэтгүүлд нийтлүүлэх вэ?” сэдэвт сургалтуудыг явуулсан.

Эрдэм шинжилгээний хуралд 1-р шатнаас шалгарсан 16 илтгэл хэлцэгдсэнээс 1-р байранд Ю.Байгалмаа нарын “Пиелонефриттэй эмэгтэйчүүдийн жирэмсний явц, төрлөгийн онцлогийг судлах асуудалд”

2-р байранд А.Дагвасүрэн нарын “Эмнэлгийн ажилчдын гар утасны гадаргууд байрлах нянгийн бохирдлыг судалсан дүн, 3-р байранд С.Алтанчимэг нарын “Үтрээний үрвсэлт өвчин үүсгэгчийг судалсан дүн” илтгэлүүд тус тус шалгарсан байна.

Шүүгчдийн бүрэлдэхүүнд ажилласан АШУҮИС-ийн НЭМС-ийн багш АУ-ы доктор Д.Гантуяа судалгааны арга зүй болон судалгааны ажил хийхэд анхаарах зүйлийн талаар зөвлөгөө өглөө. Тус эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн бүтээлүүдийг нэгтгэсэн “Эрдмийн бага чуулган-2017” илтгэлийн хураангуй хэвлэгдсэн байна.